



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.03 № 10/156

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.8 дугаар зүйлд заасан цаглаварын дагуу энэхүү аудитыг “Б энд С аудит” ХХК гүйцэтгэлээ.

2012 оны сүүлийн хагас жил, 2013 оны эхний хагас жилийн байдлаар туслах үйл ажиллагааны орлогыг 188.9 сая төгрөг үүнээс найдваргүй өр авлага хаасан 66.7 сая төгрөг, тэг үлдэгдэлтэй данснаас зарлага гаргаж орлого бууруулсан 306.9 сая төгрөг, борлуулалтын орлого дутуу тооцсон 9,031.6 сая төгрөг бүгд 9,594.1 сая төгрөгний орлого дутуу тооцож санхүүгийн тайланд буруу тусгасан байгаа нь НББ-ийн тухай хуулийн 16.1-д “Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө”, 4.1.2-д “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасныг үндэслэн дутуу бүртгэсэн орлогыг бүртгэлд тусган залруулж дээр дурьдсан зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2014 оны 3 дугаар сарын 1-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус компаний Эдийн засгийн асуудал эрхэлсэн дэд захирал, ерөнхий нягтлан бодогч Х.Жаргаланбаатар, ахлах нягтлан бодогч Л.Оюунчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР**

**“Б ЭНД С АУДИТ” ХХК-ИЙ
ЗАХИРАЛ**

ЗӨВШӨӨРСӨН:

**ЭБЦТС” ТӨХК-ИЙ ЭДИЙН ЗАСГИЙН
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ,
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ**



Л.ОДГЭРЭЛ

Д.ДАШХОРЛОО

Х.ЖАРГАЛАНБААТАР

Л.ОЮУНЧИМЭГ

070406